



**АЛБАДАН АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ШҮҮХИЙН
ШИЙТГЭХ ТОГТООЛЫГ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА**



С.БУЯНЗАЯА

*Хууль сахиулахын их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн багш,
хууль зүйн ухааны докторант*

Эх сурвалж:

Эрүүгийн хуулийн 46, 50 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 96 – 98 дугаар зүйл, Хууль зүй дотоод хэргийн сайдын 276 дугаар тушаалын хавсралт зэрэг болно.

**ЭРҮҮГИЙН ХУУЛИАР “АЛБАДАН АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ”
ОНОГДУУЛАХААР ЗААСАН ЗҮЙЛ, ЗААЛТУУД**

№	Зүйл	Заалт	Ялын цаг
1	98	98.1	251 – 450
2	99	99.2	251 – 350
3	103	103.1	251 – 400
4	107	107.1	251 – 350
5		107.2	351 – 500
6	114	114.1	100 – 200
7		114.2	251 – 500
8	115	115.1	100 – 250
9	117	117.1	251 – 300
10	122	122.1	251 – 300
11	124	124.2	300 – 400
12	127	127.1	251 – 400
13	128	128.1	251 – 400
14	129	129.1	251 – 350
15		129.2	351 – 500
16	134	134.1	250 – 350
17	145	145.1	100 – 250
18	148	148.1	100 – 250
19	153 ¹	153 ¹ .1	251 – 500
20	154	154.2	251 – 500
21	160	160.1	251 – 500
22	168	168.1	251 – 500
23	169	169.2	251 – 500

№	Зүйл	Заалт	Ялын цаг
24	171	171.2	251 – 500
25	174	174.1	251 – 500
26	175	175.1	251 – 500
27	193	193.1	251 – 500
28	219	219.1	100 – 300
29	229	229.1	100 – 200
30	230	230.1	251 – 350
31		230.2	351 – 500
32	231	231.1	100 – 150
33	232	232.1	251 – 500
34	234	234.2	251 – 350
35	236	236.1	100 – 200
36	237	237.1	251 – 350
37		237.2	351 – 500
38	242	242.1	251 – 500
39	245	245.1	100 – 200
40		245.2	300 – 500
41	247	247.1	300 – 400
42	256	256.1	200 – 300
43	258	258.1	100 – 250
44		258.2	251 – 500
45	259	259.1	100 – 250
46	266	266.1	100 – 250



Тодруулга: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан дээрх 39 зүйл ангийн 46 заалтад “Албадан ажил хийлгэх ял” оногдуулахаар хуульчилсан ба эдгээрээс өөр заалт байхгүй болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

Товчилсон нэр:

- ААХЯ – Албадан ажил хийлгэх ял
- = – /тэнцүү/ тэнцүүлж тооцно

Тодорхойлолт :

Нэг зуугаас таван зуун цагийн хугацаатайгаар, нэг өдөрт гурваас арван хоёр цагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэнэ.

Онцлог:

- ААХЯ-ыг зөвхөн үндсэн ялын чанартай оногдуулдаг.
- 100 – 500 цагийн хугацаатайгаар оногдуулдаг.
- Өдөрт 3 цагаас доошгүй, 12 цагаас хэтрүүлэхгүйгээр албадан ажил хийлгэх ял эдлүүлнэ.
- Хуульд зааснаар ААХЯ-ыг зөвхөн баривчлах ялаар сольж болно.
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар ялтныг ажлын байраар хангах үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Нэмэлт мэдээлэл:

- ААХЯ-ыг өмнө нь хуульд заасан тохиолдолд өөр төрлийн хөнгөн ялаар сольж болох заалт байсныг 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.
- Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ААХЯ-тай холбоотой Улсын Дээд Шүүхийн тайлбар байхгүй болно.

Ял оногдуулахыг хориглох	<ul style="list-style-type: none"> • хөдөлмөрийн чадваргүй этгээд • жирэмсэн эмэгтэй • гурав хүртэлх насны хүүхдтэй эх, ганц бие эцэг • тавин таваас дээш насны эмэгтэй • жараас дээш насны эрэгтэй • цэргийн жинхэнэ алба хааж байгаа этгээд
Ял тооцох	
Цагдан хоригдсон 1 хоног = 24 цаг албадан ажил хийх	Ялтан цагдан хоригдож байсан бол тухайн хоногийг харгалзан албадан ажил хийснээр тооцож биечлэн эдлэх ялаас хасч тооцно.
* Шийдвэр гүйцэтгэгч нь ажиллаагүй цагийг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцохгүй бөгөөд дутуу ажилласан цагийг нөхөж ажиллуулна.	



Ялтыг солих	
Албадан ажил хийх 8 цаг = Нэг хоног баривчлах ял	Баривчлах ялаар солих үндэслэл нь: 1. Ялтан ажлаа дур мэдэн орхих 2. Ажил олгогч, шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг биелүүлээгүй 3. Тавьсан шаардлагыг ноцтой зөрчиж зайлсхийвэл.
* Шийдвэр гүйцэтгэгч ялтны хөдөлмөр хийж байсан зохих газарт нь шалгалт хийж ААХЯ-ыг баривчлах ялаар солих тухай саналаа холбогдох баримт бичгийн хамтаар шүүхэд гарган шийдвэрлүүлнэ.	

Ял эдлүүлэхэд хяналт тавих	
Өдөр тутам хяналт тавих	Гүйцэтгэлд хяналт тавих
<ul style="list-style-type: none"> ▪ шийдвэр гүйцэтгэгч ▪ ерөнхий гүйцэтгэгч 	<ul style="list-style-type: none"> ▪ засаг дарга ▪ прокурор
* Шийдвэр гүйцэтгэгч эдгээр хоёр тохиолдолд ААХЯ-аас чөлөөлүүлэх саналаа ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж байгаа прокурорт гарган шийдвэрлүүлнэ.	

Ялаас чөлөөлөх	
<ul style="list-style-type: none"> ▪ ялтан хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан бол 	<ul style="list-style-type: none"> ▪ ялтан хөдөлмөрийн чадвараа удаан хугацаагаар алдсан бол

▪ Шийдвэр гүйцэтгэгч ялтныг албадан ажиллуулах байгууллагатай ялтны өдөрт ажиллах цаг, гүйцэтгэх үүрэг, хөдөлмөрийн нөхцлийн талаар тохиролцож биелэлтэнд нь хяналт тавина..

Ял хойшлуулах		
ялтан хүнд өвчилсөн эдгэртэл нь	ялтан жирэмсэн ▪ төрөхөөс өмнө 45 хоног ▪ төрснөөс хойш 1 жилээс илүүгүй	<ul style="list-style-type: none"> ▪ байгалийн гамшиг, аюул ▪ гэр бүлийнх хөдөлмөрийн чадвартай ганц хүн хүндээр өвчилсөн ▪ хүндэтгэх шалтгаан 3 сараас хэтрэхгүй хугацаагаар

* Шийдвэр гүйцэтгэгч эдгээр гурван тохиолдолд ААХЯ эдлүүлэхийг хойшлуулах саналаа холбогдох баримт бичгийг хамтаар шүүхэд гарган шийдвэрлүүлнэ.
--

ААХЯ оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагаанд хөтлөгдхөх баримт бичиг:

1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай ахлах гүйцэтгэгчийн тогтоол
2. Мэдэгдэл
3. Шийдвэр гүйцэтгэгчийн тэмдэглэл
4. Ялтны бүртгэх хуудас



5. Ялтны баталгаа гаргах хуудас
6. Албадан ажил хийлгэх ялын цагийн бүртгэл
7. Албадан ажил хийлгэх ял бүхий ялтныг ажиллуулах тухай гэрээ
8. Ялтанд сануулга өгсөн тухай тогтоол
9. Прокурор ялтны хувийн хэрэгтэй танилцсан тухай тэмдэглэл
10. ААХЯ-ыг өөр терлийн ялаар солих тухай шийдвэр гүйцэтгэгчийн санал
11. Албадан ажил хийлгэх ял дууссан буюу түр завсарласан тухай тэмдэглэл
12. Шаардлагатай бусад шийдвэр гүйцэтгэх ажиллагааны баримт бичиг.